



**БОЛОВСРОЛЫН
ЯАМ**



**БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БОЛОВСРУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ

ЗӨВЛӨМЖ

УЛААНБААТАР 2025

АГУУЛГА

Ерөнхий боловсролын сургуулийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний боловсруулалтыг сайжруулах зөвлөмж	3
Удиртгал	3
Зөвлөмжийн зорилго	3
Зөвлөмж хэнд зориулагдах	3
Зөвлөмжийн ач холбогдол	3
Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах нь яагаад чухал вэ?	4
Ерөнхий боловсролын сургуулиудын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд хийсэн баримт бичгийн шинжилгээний үр дүнгээс	5
Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах зөвлөмж	6
Нэг. Нийтлэг үндэслэл боловсруулах зөвлөмж	6
Төлөвлөгөөний зорилго	6
Баримтлах зарчим	7
Хамрах хүрээ	7
Удирдлага зохион байгуулалт	7
Хоёр. Танилцуулга боловсруулах зөвлөмж	10
Гурав. Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах төлөвлөгөө боловсруулах зөвлөмж	12
Дөрөв. Аюулт үзэгдэл, гамшиг ослын үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах зөвлөмж	15
Тав. Аюулгүй цэгт цугларах, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө боловсруулах зөвлөмж	16
Зургаа. ЕБС-ийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хавсралт	18
Гамшгийн эрсдэлийн үнэлгээ	29
Зөвлөмж	29
Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулахад анхаарах зүйлс	31
Санал	32

Ерөнхий боловсролын сургуулийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний боловсруулалтыг сайжруулах зөвлөмж

Удиртгал

Гамшгийн эрсдэл нь боловсролын байгууллагын тогтвортой үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийн нэг бөгөөд сурагчдын амь нас, эрүүл мэндэд ноцтой аюул учруулдаг. Иймд ерөнхий боловсролын сургуулиудад гамшгаас хамгаалах төлөвлөлтийг шинжлэх ухаанч үндэслэлтэй орчин үеийн арга зүйд тулгуурлан боловсруулж, хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой.

Ерөнхий боловсролын сургуулиудын гамшгаас хамгаалах төлөвлөлт нь сурагчдын аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулахад чухал үүрэгтэй.

Онцгой нөхцөл байдал нь урьдчилан таамаглах боломжгүй ч түүнд бэлэн байх нь эрсдэлийг бууруулах, хохирлыг багасгах, хэвийн үйл ажиллагаанд хурдан эргэн орох үндэс болно. Ерөнхий боловсролын сургуулийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд баримт бичгийн шинжилгээ хийсний үндсэн дээр уг төлөвлөгөөг илүү бодитой, хэрэгжихүйц, тасралтгүй сайжирдаг баримт бичиг болгох зорилгоор энэхүү зөвлөмжийг боловсруулав.

Зөвлөмжийн зорилго

Гамшиг, онцгой байдлын үеийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах, гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед боловсролын үйл ажиллагаа тасралтгүй хэвийн зохион байгуулах чадавхыг дээшлүүлэхэд оршино.

Зөвлөмж хэнд зориулагдах

Ерөнхий боловсролын сургуулиуд “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө” боловсруулахдаа ашиглана.

Зөвлөмжийн ач холбогдол

Сургууль нь бодит төлөвлөгөөтэй болсноор гэнэтийн аюулын үед сандарч тэвдэхгүй байх нөхцөл бүрдэнэ.

Сурагчдад гамшиг, аюулын үед анхны тусламжийг хэн үзүүлэх, эцэг эхчүүдэд хэн мэдээлэл өгөх зэрэг тасралтгүй ажиллах боломжийг олгоно.

Сурагчид болон багш нар аюулын дохио дуугарахад автоматаар зөв үйлдэл хийж сурна.

Шаардлагатай багаж хэрэгсэл нь ажилладаг хүртээмжтэй байх нөхцлийг бүрдүүлснээр эрсдэлийг хохирол багатай даван туулж сурна.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах нь яагаад чухал вэ?

Ерөнхий боловсролын сургуулиудын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд хийсэн шинжилгээний үр дүнгээс харахад:

1. Ерөнхий боловсролын сургуулиудын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны А/388 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан “Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний загвар”-ын дагуу боловсруулах
2. Хичээл сургалтын үйл ажиллагааг тасалдалгүй зохион байгуулах арга хэмжээг тусгах
3. Хичээл сургалтын үйл ажиллагааны явцад болзошгүй аюулт үзэгдэл, осол тохиолдвол авах арга хэмжээг нарийвчлан тусгах
4. Гамшиг, онцгой нөхцөл байдалд өртсөн хүүхдүүдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг тусгах зэрэг боловсролын салбарын онцлогтой холбоотой асуудлыг зохицуулах шаардлагатай байна.

“Орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд Боловсролыг яаж тасалдалгүй явуулах талаар нэг ч үг өгүүлбэр тусгагддаггүй”.

Засаг даргатай хийсэн ярилцлагаас

Тиймээс ерөнхий боловсролын сургуулиуд Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах нь гамшиг, онцгой нөхцөл байдал тохиолдохоос өмнө урьдчилан сэргийлэх, багш, ажилтан, сурагчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах, хохирол багатай даван туулах, хичээл сургалтын үйл ажиллагаа хэвийн тасалдалгүй зохион байгуулахад чухал ач холбогдолтой юм.

Ерөнхий боловсролын сургуулиудын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд хийсэн баримт бичгийн шинжилгээний үр дүнгээс

Судалгаанд хамрагдсан сургуулиудын:

- 91.0 хувь нь “Нийтлэг үндэслэл” хэсгийг,
- 72.0 хувь нь “Танилцуулга” хэсгийг,
- 9.0 хувь нь “Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах” төлөвлөгөөг,
- 64.0 хувь нь “Аюулт үзэгдэл, гамшиг ослын үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг
- Бүх сургууль “Аюулгүй цэгт цугларах, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө”-г тус тус боловсруулаагүй байна.

Мөн :

- 90 хувь нь гамшгаас хамгаалах мэргэжлийн анги байгуулсан тушаалгүй, хүч хэрэгсэл нөөцийн судалгаагүй, ажлын зураггүй
- 82.0 хувь нь гамшгаас хамгаалах удирдлага зохион байгуулалтын бүдүүвчгүй, холбоо зарлан мэдээллийн схемгүй,
- Бүх сургуулиуд ажлын тусгай горимд шилжих тушаал, ажлын тусгай горимд шилжин ажиллах төлөвлөгөө, тогтвортой үйл ажиллагааны төлөвлөгөө тус тус байхгүй байсан.

Сургуулиуд гамшгаас хамгаалах төлөвлөгөөг холбогдох заавар, журамд нийцүүлэн боловсруулах чадавх сул байгааг баримт бичгийн шинжилгээний үр дүн харуулж байна. Иймд гамшгаас хамгаалах төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагын арга зүйн дэмжлэгтэйгээр холбогдох төсөв, нөөцтэй уялдсан, хэрэгжихүйц, бодит амьдралд хэрэгжихүйц төлөвлөгөө боловсруулах шаардлагатай байна.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах зөвлөмж

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны А/388 дугаар тушаалаар баталсан байгууллагын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг дараах бүтцийн дагуу боловсруулна.

1. Нийтлэг үндэслэл
2. Танилцуулга
3. Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө
4. Аюулт үзэгдэл, гамшиг ослын үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээ төлөвлөгөө
5. Аюулгүй цэгт цугларах, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө
6. Хавсралт
 - Гамшгаас хамгаалсан мэргэжлийн анги байгуулсан тушаал,
 - Ажлын тусгай горимд шилжих тушаалын төсөл,
 - Гамшгаас хамгаалах удирдлага, зохион байгуулалтын бүдүүвч,
 - Холбоо, зарлан мэдээллийн схем,
 - Хүч хэрэгсэл нөөцийн судалгаа,
 - Ажлын зураг, ажлын тусгай горимд шилжин ажиллах төлөвлөгөө,
 - Тогтвортой үйл ажиллагааны төлөвлөгөө

Нэг. Нийтлэг үндэслэл боловсруулах зөвлөмж

“Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний загвар”-ын дагуу нийтлэг үндэслэл хэсэгт **Төлөвлөгөөний зорилго, төлөвлөгөө боловсруулахад Баримтлах зарчим, Хамрах хүрээ, Удирдлага зохион байгуулалт** гэсэн 4 хэсгээс бүрдэнэ.

Төлөвлөгөөний зорилго

- *.....аймаг / хот -ынсум / дүүргийн ... дүгээр сургуульд тохиолдож болзошгүй газар хөдлөлт, ... зэрэг байгалийн гамшигт үзэгдэл, зуд ... зэрэг онцгой нөхцөл байдлын үед сургуулийн багш, ажилчдын амь нас, эрүүл мэндийг эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх, хохирол багатай даван туулахад төлөвлөгөөний зорилго оршино.*

Баримтлах зарчим

Байгууллагын эрсдэл эмзэг байдал, чадавхын үнэлгээнд тулгуурласан, хэрэгжих үндэслэлтэй, ажилтан албан хаагчид, салбар нэгжүүдийн хамтын ажиллагаа, оролцоог хангасан байх зарчмыг баримтлана.

- ЕБС-ийн эрсдэл, эмзэг байдал болон чадавхын үнэлгээнд тулгуурлана.

- ЕБС-ийн багш, ажилтан, албан хаагчдын оролцоог хангана.
- Орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй уялдуулна.

Хамрах хүрээ

Хамрах хүрээ хэсэгт гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд салбар нэгж, хувь хүн ямар үүрэг оролцоотой оролцохыг товч дурдана.

Удирдлага зохион байгуулалт

Хүснэгт 1. Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн гишүүдийн гүйцэтгэх чиг үүрэг

№	Албан тушаал	Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангид ажиллах албан тушаал	Гүйцэтгэх чиг үүрэг	Нэмэлт үүрэг
1	Захирал	Мэргэжлийн ангийн дарга бөгөөд гамшгийн үеийн удирдлагын байрны дарга	Дээд шатны байгууллага болон онцгой байдлын газартай холбогдоно. Гамшгийн үеийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж шийдвэр гаргана.	
2	Менежер	Орлогч бөгөөд сургалт сурталчилгаа хариуцсан ажилтан	Гамшгийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, бүлгүүдийн уялдаа холбоог хангана.	
3	Багш	Хэв журам, аюулгүй байдал хариуцсан ажилтан	Нүүлгэн шилжүүлэлтийн үед зам чөлөөлөх, түгжрэл үүсгэхгүй байх. Цугларах цэг дээр анги удирдсан багш нарын ирцийг нэгтгэж, "Сурагч бүрэн эсэх" мэдээг гаргах. Сургуулийн гаднах орчинд зөвшөөрөлгүй хүн, машин нэвтрүүлэхгүй байх. Эцэг эхчүүдэд мэдээлэл өгөх, хүүхдийг хүлээлгэн өгөх ажлыг зохицуулах.	
4	Нийгмийн ажилтан	Холбоо зарлан мэдээлэл хариуцсан ажилтан	Дохиоллын систем ажиллуулах, цагаан хоолойгоор зааварчилгаа өгөх Дээд шатны байгууллага болон мэргэжлийн байгууллагатай холбоо барих Гамшгийн үеийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг штабын даргад тогтмол хүргэх	
5	Ерөнхий нягтлан бодогч	Хангалт хариуцсан ажилтан	Шаардлагатай багаж хэрэгсэл (олс, хүрз, элс гэх мэт) зэргээр хангах.	

ЕБС-ийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлагыг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23.1-д заасны дагуу сургуулийн захирал хэрэгжүүлж, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, төлөвлөлт, бэлтгэл бэлэн байдлыг хангах, гамшгийн хор уршгийг арилгах удирдлага зохион байгуулалтыг Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн дарга хариуцан гүйцэтгэнэ. Сургууль эрсдэлийн үнэлгээгээ хийлгэж, үнэлгээний дүгнэлтэд үндэслэн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулна.

Захирал мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний албан тушаал, гүйцэтгэх чиг үүргийг албан тушаал тус бүрээр бичиж тушаал гаргана.

Хүснэгт 2. Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн орон тооны бус бүлгийн тусгай үүрэг гүйцэтгэх бүлгүүдийн томилгоот бүрэлдэхүүний гүйцэтгэх чиг үүрэг

№	Багийн нэр	Албан тушаал	Гүйцэтгэх үүрэг	Нэмэлт үүрэг
1	Эрэн хайх, аврах бүлэг	Биеийн тамирын багш нар	<ul style="list-style-type: none"> Сургуулийн барилга дотор үлдсэн, бэртсэн, гацсан сурагч, ажилчдыг эрэн хайх. Нуранги, гал түймэр, утааны бүсээс хүмүүсийг аюулгүй гарцаар гаргах. Өөрөө бие даан гарах чадваргүй хүмүүсийг дамнуурга болон бусад хэрэгслээр зөөвөрлөх. Аврах ажиллагааны үеийн аюулгүй байдлыг хангах (өөрөө эрсдэлд орохоос сэргийлэх) 	
2	Анхны тусламжийн бүлэг	Сургуулийн эмч, биологийн багш, эрүүл мэндийн хичээл заадаг багш нар	<ul style="list-style-type: none"> Цугларах цэг дээр "Эмнэлгийн анхны тусламжийн цэг" байгуулах. Гэмтлийн зэргийг тогтоох Цус тогтоох, боолт хийх, амьсгал дэмжих, чиг тавих ажиллагааг хийх. Бэртсэн хүмүүсийн бүртгэл хөтөлж, түргэн тусламжийн эмчид мэдээлэл өгөх 	

3	Гал унтраах бүлэг	Техник ажилчид, жижүүрүүд, цахилгаанчин	<ul style="list-style-type: none"> ● Галын голомтыг нэн даруй илрүүлж, гал унтраах ангид мэдээлэх. ● Барилгын цахилгаан, хий, дулааныг таслах. ● Галын хор, дотор усны цорго ашиглан галын тархалтыг хязгаарлах. ● Галын бүсээс шатамхай болон тэсэрч дэлбэрэх бодисыг зайлуулах. 	
4	Нүүлгэн шилжүүлэх бүлэг	Анги удирдсан багш нар	<ul style="list-style-type: none"> ● Хүүхдүүдийг тогтоосон замаар аюулгүй гарцаар гаргах. ● Ангийн журналыг авч гарч, цугларах цэг дээр хүүхдүүдээ бүрэн байгаа эсэхийг тоолж, штабт илтгэх. ● Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлж, хүүхдүүдийг тайван байлгах. 	

Хүснэгт 1, 2-т үзүүлсэн загварын дагуу Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн гишүүд болон орон тооны бус бүлгийн тусгай үүрэг гүйцэтгэх бүлгүүдийн томилгоот бүрэлдэхүүний гүйцэтгэх чиг үүргийг тодорхой зааж боловсруулна.

Хоёр. Танилцуулга боловсруулах зөвлөмж

Сургуулийн байршил, хаяг, барилга байгууламжийн ерөнхий зохион байгуулалт, хүчин чадал, эрсдэлийн удирдлагын чадавхын үнэлгээ гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

.....аймгийнсумындугаар сургуулийн байршил, хаяг товч танилцуулга

Сургууль, дотуур байрны барилга байгууламжийн ерөнхий зохион байгуулалт:

1) Газрын ерөнхий төлөвлөлт

- Сургууль ашиглалтад орсон он
- Сургуулийн эзэмшил газрын хэмжээ, хэлбэр, хил хязгаар
- Барилга байгууламжуудын байршлын уялдаа (хичээлийн байрууд, анги, спорт заал, хоолны газар, урлаг заал гэх мэт)
- Зам, орц гарцын зохион байгуулалт (сургуулийн орц, автомашины зогсоол, явган хүний зам)
- Ногоон байгууламж, амрах хэсэг, хүүхдийн тоглоомын талбай
- Гадаа спортын талбай
- Аюулгүй байдал (Галын гарц, хашаа, хяналтын систем, гэрэлтүүлэг)
- Хог хаягдлын цэг, хадгалах байр

2) Инженерийн дэд бүтэц

- Цахилгаан
- Дулаан
- Усан хангамж
- Ариутгах татуурга
- Агааржуулалт
- Гэрэлтүүлэг
- Галын аюулгүй байдлын систем, дохиолол
- Интернет, холбоо, мэдээллийн сүлжээ

Сургуулийн хүчин чадал:

1) Сургуулийн барилга, дэд бүтэц

- Анги танхимын тоо, багтаамж (нэг ангид сурах хүүхдийн тоо)
- Лаборатори, кабинет (Физик, хими, биологи, мэдээлэл зүй, англи хэл гэх мэт)
- Удирдлага, багш нарын өрөө
- Номын сан, уншлагын танхим
- Спорт заал
- Клуб, дугуйлангийн өрөө
- Хоолны газар
- Ариун цэврийн байгууламж
- Дотуур байрны хүчин чадал (унтлагын өрөө, ариун цэврийн өрөө, амралтын хэсэг)

2) Хүний нөөц

- Багш нарын тоо, мэргэжил, ачаалал
- Захиргаа удирдлага
- Үйлчилгээний ажилтнууд
- Нэг багшид ноогдох сурагчийн тоо

3) Тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн

- Компьютер, проектор, самбар, лабораторийн багаж хэрэгсэл
- Хичээлийн ном сурах бичиг, гарын авлага
- Дижитал сургалтын орчин (интернэт, программ хангамж, e-learning систем)

4) Сургалтын бүтэц ба хөтөлбөрийн хүчин чадал

- Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн тоо
- Тусгай хэрэгцээт боловсролын дэмжлэг
- Клуб, дугуйлангийн хүрэлцээ

5) Орчны хүчин зүйл

- Байгаль орчны аюулгүй байдал (хөдөлгөөний аюулгүй байдал, агаар, дуу чимээ)
- Хүртээмж (Гэрэлтүүлэг, дулаан, унаа тээвэр)
- Суралцагчийн хөгжлийг дэмжих орчин

**Гурав. Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах төлөвлөгөө
боловсруулах зөвлөмж**

Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах төлөвлөгөөнд ажилтан, албан хаагчдад гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, мэдлэг, дадлага олгох арга хэмжээг төлөвлөнө. Тухайлбал, хүн нэг бүрийн гүйцэтгэх үүрэг, гамшгаас хамгаалах багаж хэрэгслийг бүрдүүлэх, ажиллуулах арга гэх мэт бэлэн байдлыг хангахтай холбоотой сургалт, дадлагыг хэн хэрхэн зохион байгуулах талаар тусгаж боловсруулна.

Хүснэгт 3. “Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө”-г загвар

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн	Хугацаа	Хариуцах нэгж/албан тушаалтан	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Шаардагдах төсөв
Нэг. Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны чиглэлээр¹						
1	Хөөс болон CO ₂ гал унтраагуурыг ашиглаж сурах	1. ... сурагчдын ... нь гал унтраагуурыг ашиглаж чаддаг болно 2. ... багшийн ... нь гал унтраагуурыг ашиглаж чаддаг болно 3. ... ажилтны ... нь гал унтраагуурыг ашиглаж чаддаг болно	Жил бүрийн 3 дугаар сард			
2						
3						
Хоёр. Эрсдэлийг бууруулах чиглэлээр						
1	Галын хорны хүрэлцээний тооцоо судалгаа гаргаж, нэмж байршуулах					
2	Гал илрүүлэх дохиоллын систем суурилуулах					
3						
Гурав. Гамшгаас хамгаалах нөөц бүрдүүлэх чиглэлээр						
Дөрөв. Гамшигтай тэмцэх чадавхыг сайжруулах, бэлэн байдлыг хангах чиглэлээр						

¹

	Хүн нэг бүрийн үүргэвч бүрдүүлэх					
Тав. Хичээл сургалтын үйл ажиллагааг тасралтгүй хүргэх чиглэлээр						
1	Сургуулийн бэлэн байдлыг хангах					
2	Техник, технологийн хязгаарлагдмал байдалтай холбоотой шийдэл гаргах	Теле хичээлүүдийг багш өөрийн үйл ажиллагаатай хослуулан ашигладаг болсон байна.				
		Радио долгионоор дамжуулан үндсэн хичээлийг заах контент бэлтгэх. Энэ нь интернэтгүй газарт үр дүнтэй болсон байна.				
		Хичээлийн агуулгыг цомхон байдлаар хэвлэж, багцаар сурагчдад хүргэх. Эдгээрийг багш нар өөрийн гарын авлага хэлбэрээр бэлтгэсэн байна.				
3	Хичээл сургалтын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах	Теле хичээлээр заасан агуулгыг бататгах зорилгоор сурагчдад дасгал, даалгавар өгдөг байх. Эдгээрийг интернэттэй сурагчдад онлайнаар, харин интернэтгүй сурагчдад хэвлэмэл материал				

		хэлбэрээр хүргэх, хичээлийн үр дүнг үнэлэх, үнэлгээ дээр тулгуурлан сайжруулалтыг хийдэг болсон байна.				

Хүснэгт 3-ийг хэрхэн бөглөх талаар доор тодорхой тайлбарлав.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах зорилготой тодорхой ажил, арга хэмжээг хэлнэ. Арга хэмжээнд тавих гол шаардлага бол төлөвлөсөн арга хэмжээ тодорхой байхыг шаардана. Арга хэмжээг ерөнхий, хэмжих боломжгүй байдлаар тусгахгүй. (Жишээ нь: *Сургуулийн сурагчдад гамшгийн боловсрол олгох сургалт гэж тодорхойлохгүй. Учир нь гамшгийн боловсрол олгох сургалт нь гамшгийн төрөл тус бүрээр маш олон байгаа. Үүнээс танай орон нутаг, дүүргийн газар зүйн байршил, гамшигт үзэгдлийн давтамж, цаг агаарын сүүлийн үеийн өөрчлөлтийн давтамж зэрэг олон хүчин зүйлийг харгалзаж өөрийн сургуульд эрэлт хэрэгцээтэй арга хэмжээг төлөвлөнө. Тиймээс жишээ болгож “галын хорыг хэрэглэж, гал унтраах сургалт зохион байгуулна гэж тодорхой арга хэмжээг төлөвлөнө. Төлөвлөгөө боловсруулахад гаргадаг гол алдаа бол арга хэмжээг ерөнхий тусгасантай холбоотой байдаг*).

Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн

Тодорхой арга хэмжээг төлөвлөснөөр гарах суурь түвшнийг тодорхойлж ахицыг жил бүрээр (улирал, сар бүрээр) хэмжиж, ямар үр дүнд хүрэх зорилттой байгаагаа тодорхойлно. (Жишээ нь: *Ажилтнуудын 90% гамшгаас хамгаалах сургалтад хамрагдсан байна гэж тодорхойлохгүй. Суурь түвшин гэдэг нь сургуулийн хэмжээний нийт сурагч, багш, ажилтан тус бүрээс галын хорын хэрэгслийг ашиглаж, гал унтрааж чаддаг хэдэн багш, хэдэн сурагч, хэдэн ажилтан байгааг тус тус бичнэ. Энэ бол суурь түвшин. Хүрэх үр дүн буюу зорилтот түвшин бол энэ суурь түвшнийг он оноор ахиулж нэмэгдүүлснээр сургуулийн хэмжээний бүх сурагч, багш, ажилтан галын хорыг хэрэглэж гал унтрааж чаддаг болсноор хүрнэ гэж зорьсон үр дүндээ хүрэхийг хэлнэ. Хэмжих нэгж нь гал унтрааж чаддаг болсон хүний тоо юм*).

Арга хэмжээний шалгуур нь тодорхой, хэмжигдэхүйц, хэрэгжихүйц, ач холбогдолтой, цаг хугацаатай байна.

Хугацаа

Тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэх хугацаа, давтамж тодорхой байна. (Жишээ нь: *Жил бүрийн 3 дугаар сард, улирал тутамд 1 удаа, 202... оны 4 дүгээр сард гэх мэт*)

Хариуцах нэгж, албан тушаалтан

Үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлэх нэгж, багш, ажилтны албан тушаалаар бичнэ. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд хийсэн шинжилгээний үр дүнгээс үзэхэд зарим ерөнхий боловсролын сургуулиуд хариуцан хэрэгжүүлэх эзнийг хүний оноосон нэрээр бичсэн байсан. Тиймээс хариуцах нэгж, албан тушаалтан хүснэгтэд хүний оноосон нэрийг бичихгүй. (Жишээ нь: *Сургалтын менежер ... , байгалийн ухааны заах аргын нэгдэл гэх мэт*)

Хамтран хэрэгжүүлэх

Тухайн ажлыг хамтран гүйцэтгэх байгууллага, албан тушаалтан (Жишээ нь: *Орон нутгийн Онцгой байдлын газар, орон нутгийн Засаг даргын тамгын газар ЗДТГ, эмнэлэг гэх мэт*)

Шаардагдах төсөв

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51.2-т төрийн байгууллага тухайн жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүйг зарцуулахаар тооцон төсөвт тусгаж зарцуулна гэж заасан байдаг. Энэхүү хуулийн заалтыг хэрэгжүүлэн төлөвлөгөөнд тусгаж оруулах нь зүйтэй².

² “Онцгой нөхцөл байдлын үеийн Ерөнхий боловсролын Сургуулийн бэлэн байдал” судалгааны үр дүнгээс үзэхэд гамшиг, онцгой нөхцөл байдлын үед хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах төсөв, хөрөнгийг огт тусгаагүй байгаа нь бодит амьдралд хэрэгжихүйц төлөвлөгөө болж чадахгүй байгааг харуулж байна.

Тиймээс хуулийн хэрэгжилтийг ханган төсвийг төлөвлөгөөнд зайлшгүй тусгах шаардлагатай байна.

Дөрөв. Аюулт үзэгдэл, гамшиг ослын үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах зөвлөмж

Орон нутагт томоохон гамшиг, осол тохиолдсон үед болон тухайн барилга байгууламжид гал түймэр, үер, хөлдөлт, цацраг химийн хорт бодис алдагдах, барилга байгууламж нурах зэрэг аюул, осол тохиолдсон үед шуурхай ажиллагааг хэрхэн зохион байгуулах дэс дарааллаар төлөвлөнө. Тухайлбал: Зарлан мэдээлэл дамжуулах, шуурхай штаб, хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх, хүч хэрэгслийг төлөвлөх, хуваарилах, мэдээ мэдээлэл цуглуулах, дамжуулах, ар тал хангалтыг зохион байгуулах гэх мэт асуудлыг хэн, хэзээ, хэрхэн зохион байгуулах талаар төлөвлөгөөнд тусгана.

Хүснэгт 4. Аюулт үзэгдэл, гамшиг ослын үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөө-ний бүтэц

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Багтаамж	Хугацаа			Хариуцах албан тушаалтан, нэр
		Минут	Цаг	Хоног	
Жнь: Ажилтан, албан хаагчдад гамшиг аюулын тухай зарлан мэдээлэл хүргэх					
Жнь: Гал түймрийг унтраах					
Жнь: Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх					

Тав. Аюулгүй цэгт цугларах, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө боловсруулах зөвлөмж

Сургуулийн барилга дотор буй хүмүүсийг гамшиг, ослын үед хэрхэн аюулгүй, түр цугларах талбайд гаргах, бүртгэх, нүүлгэн шилжүүлэх хангалт хэрхэн зохион байгуулах талаар тусгана. Байгууллагын цахим мэдээлэл, санхүүгийн болон бусад чухал баримтыг мөн хэрхэн хадгалах, зөөвөрлөх талаар төлөвлөж боловсруулна.

Сургуулиуд аюулгүй цэгт цугларах, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө нь дараах бүтэцтэй байна.

Хүснэгт 5. Аюулгүй цэгт цугларах, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний бүтэц

№	Байгууллагын дэргэдэх аюулгүй талбай	Талбайн хэмжээ	Бүртгэл явуулах албан тушаалтан /нэр, утасны дугаар/	Аюулгүй талбайд байрших ажилтан албан хаагч, сурагчид	Бүртгэлийн нэгдсэн мэдээ гаргах албан тушаалтан /нэр, утасны дугаар/	Тайлбар

Байгууллагын дэргэдэх аюулгүй талбайг тодорхойлох

- Аюулгүй талбайг сонохдоо сургуулийн ойролцоо газар хөдлөлт, гал түймэр, үер хүчтэй салхи зэрэгт өртөхөөргүй, аюулгүй байх тэгш барилга байгууламж, цахилгаан шон, мод ургамал багатай талбайг сонгоно.
- Хэрвээ сургуулийн хашаанд багтахаргүй бол орон нутгийн захиргаа, Цагдаа, Онцгой байдлын газрын дэмжлэгтэйгээр гадна талбайг сонгоно. *(спортын талбай, соёлын төвийн талбай, цэцэрлэгт хүрээлэн гэх мэт)*

Талбайн хэмжээг тооцох

- Сургуулийн ойролцоох талбайг сонгож талбайн хэмжээг тооцож оруулна.
- Нэг хүнд 1.5-2 м.кв зай ноогдохоор тооцож, нийт сурагч, багш, ажилчдыг хамруулсан талбайн хэмжээг урьдчилан тооцоолно.
- Хэрэв бүх хүнийг нэг дор багтаах боломжгүй бол нөөц талбайтай байх

Бүртгэл явуулах албан тушаалтныг томилох

- Бүртгэлийг ангид багш нар явуулах бөгөөд төвлөрсөн мэдээллийг нэгтгэх, хариуцсан зохицуулагчаар сургалтын менежер, нийгмийн ажилтан томилох
- Заавал нэр, албан тушаал, холбоо барих дугаарыг хүснэгтэд тодорхой бичнэ.

Аюулгүй талбайд байрших дэг журам

- Анги бүр урьдчилан заасан байрлалдаа жагсаж зогсоно
- Аюулгүй цэгт цугларах үед багш, ажилчид сурагчдыг чиглүүлнэ
- Талбайд машин оруулахыг хориглох, сурагчид аюулгүй талбайд хэвтэх, суухыг хориглох гэх мэт дотоод дэгийг тусгана.

Бүртгэлийн нэгдсэн мэдээ гаргах албан тушаалтан /нэр, утасны дугаар/

- Анги тус бүрийн ирцийн мэдээллийг илгээх боломжтой (*Гар утас, радиостанц, мессеж групп*)
- Нэгдсэн мэдээллийг нэгтгэн ОБГ/сумын ЗДТГ-т мэдэгдэх эрх бүхий хүнийг хүснэгтэд бичнэ.
- Багш, ажилтан, албан хаагчдын бүртгэлийн нэгдсэн мэдээ гаргах албан тушаалтны нэр, утасны дугаарыг тодорхой оруулах

Тайлбар хэсэгт

- Хэрэв талбайн нөхцөл аюултай гэж үзвэл нүүлгэн шилжүүлэх боломжтой өөр маршрутыг тусад нь хавсаргана.
- Сургуулийн удирдлагын гарын үсэг, байгууллагын тамга даруулан албан ёсны баримт болгон хадгална.

Зургаа. ЕБС-ийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хавсралт

Сургуулийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хавсралт дараах хэсгээс бүрдэнэ.

1. Тушаал, шийдвэр, дүрэм, журмын хэсэг /штаб, мэргэжлийн анги байгуулсан тушаал/, ажлын тусгай горимд шилжүүлэх тушаалын төсөл гэх мэт
2. Гамшгаас хамгаалах удирдлага, зохион байгуулалтын хэсэг. Хүн нэг бүрийн гүйцэтгэх үүргийг тодорхойлж тусгасан байна.
3. Холбоо зарлан мэдээллийн схем /байгууллагын удирдлага, ажилтан албан хаагчдад хэрхэн мэдээлэл хүргэх зарлан мэдээллийн схем, холбогдох утасны дугаар, гэрийн хаяг гэх мэт/
4. Ажлын болон барилгын план зураг /гамшгаас хамгаалах удирдлагын ажлын зураг, барилга байгууламжийн план зураг, давхаруудын зураг, цугларах цэг, зарлан мэдээллийн дохио дамжуулах хэрэгсэл, барилгаас гарах аюулгүйн гарцын зураглал гэх мэт/
5. Хүч хэрэгсэл, нөөцийн судалгаа

.....аймгийнсумынсургууль.

Захирлын тушаал

Гамшгаас хамгаалах мэргэжлийн анги байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.3 дахь заалт, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.2.4 дэх заалт, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 75 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь :

1. сургуулийн хэвийн үйл ажиллагааг хангах, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хувцас, багаж хэрэгслийн жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сургаж дадлагажуулах, бэлтгэл бэлэн байдлыг хангах, мэргэжлийн ангид хөтлөгдөх баримт бичгүүдийг тухай бүр шинэчилж байхыг гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн дарга /...../-д даалгасугай.

3. Гамшгаас хамгаалах хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь заалтад заасны дагуу гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлыг төлөвлөх, зориулалтын дагуу зарцуулах, мэргэжлийн ангид шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэж, ажиллах нөхцөлөөр хангахыг Санхүү, аж ахуйн тасгийн дарга /...../-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ...../ /

Захирлын 20.... оныдүгээрсарынний
 өдрийнтоот тушаалын нэгдүгээр хавсралт

Хүснэгт 6. Сургуулийн гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн


Д/д	Албан тушаал		Овог нэр
	Томилгоожсон	Үндсэн	
1	Мэргэжлийн ангийн дарга	Захирал/менежер	
2	Орлогч бөгөөд сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтан	Багш	
3	Хэв журам, аюулгүй байдал хариуцсан ажилтан	Багш	
4	Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтан	Багш	
5	Анхны тусламжийн бүлгийн дарга	Эмч	
6	Хангалт хариуцсан ажилтан	Нягтлан бодогч	
7	Гал унтраах бүлгийн дарга		
8	Нүүлгэн шилжүүлэх бүлгийн дарга		
9		

Захирлын 20.... оныдүгээрсарынний
өдрийнтоот тушаалын нэгдүгээр хавсралт

*Хүснэгт 7. Сургуулийн гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн ажлын хувцас,
багаж хэрэгслийн жагсаалт*

Д/д	Ажлын хувцас, багаж хэрэгслийн нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг
1	Нүдний хамгаалах хэрэгсэл	ширхэг	
2	Малгай, каск	Ширхэг	
3	Ажлын хувцас /өвөл, зуны/	Хос	
4	Ажлын гутал	хос	
5	Бээлий	хос	
6	Цув	ширхэг	
7	Гар чийдэн	ширхэг	
8	Мяндсан олс	метр	
9	Бэхэлгээний бүс	ширхэг	
10	Хүрз	ширхэг	
11	4 хүний майхан	ширхэг	
12	Аяны хөнжил	ширхэг	
13	Эмийн сан, анхны тусламжийн иж бүрдэл	хайрцаг	
14	Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл		
15		

Хоёр. Гамшгаас хамгаалах удирдлага, зохион байгуулалт



.....сургуулийн хэмжээнд
зарлан мэдээллийн дуут дохио дамжуулах журам

Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг сургуулийн хэмжээнд үнэн зөв, шуурхай хүргэх, багш, ажилчид, оюутнуудыг тогтоосон дохиогоор ажиллах арга ажиллагаанд дадлагажуулах ажлыг зохион байгуулахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

- Дуут дохио (сирень) ...минутын хугацаатайгаар 1 удаа дуугарахад.....байгууллагын штабын бүрэлдэхүүнбайранд цугларна.
- Дуут дохио (сирень) ...минутын хугацаатайгаар 2 удаа дуугарахад..... мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн томилгоот техник, багаж хэрэгсэлтэйгээр заасан газарт цугларна.
- Дуут дохио (сирень) ...минутын хугацаатайгаар 3 удаа дуугарахад байгууллагын нийт ажилтан албан хаагчид томилгоожуулсан аюулгүй талбайд гарна.
-

Гамшгаас хамгаалах хүч, хэрэгсэл, нөөц хангамжийн бэлэн байдал

Сургуулийн гамшгаас хамгаалах албаны бүтэц, зохион байгуулалт, гамшгийн үед ажиллах шуурхай бүлгүүд, мэргэжлийн ангийн томилгоо, хүч хэрэгсэл, нөөцийн хангамж, бэлэн байдал.

Гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл:

- Үндсэн хүч хэрэгсэл (*сургуулийн гамшгаас хамгаалах албаны хүч, хэрэгсэл*)
- Сумын гамшгаас хамгаалах албаны хүч хэрэгсэл, мэргэжлийн анги, бүлгүүд
- Аймгийн онцгой байдлын газар, хэлтсийн хүч хэрэгсэл
- Бусад (*аж ахуйн нэгж, олон улсын байгууллага, сайн дурынхан, иргэд*)

Нөөц хангамжийн бэлэн байдал: Үүнд

- Ундны ус
- Хоол хүнс
- Анхны тусламжийн хэрэгсэл
- Харилцаа холбоо, мэдээллийн хэрэгсэл
- Хамгаалах хэрэгсэл
- Сэтгэл зүйн дэмжлэгийн материал
- Бусад

Хүснэгт 8. Гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл

	Мэргэжлийн ангийн нэр	Томилгоожсон хүний тоо	Томилгоожсон автомашины марк, улсын дугаар	Үүрэг гүйцэтгэх техник, багаж хэрэгслийн нэр, төрөл, тоо	Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл		Тайлбар
					Амьсгал хамгаалах хэрэгсэл	Арьс хамгаалах хэрэгсэл	
1	Аврах бүлэг						
2	Цахилгааны аваар техникийн бүлэг						
3	Хэв журам сахиулах бүлэг						

Хүснэгт 9. Мэргэжлийн ангийн аврах багаж хэрэгсэл, техник, хэрэгсэл

д/д	Аврах багаж хэрэгсэл, техникийн нэр	Тоо	Хамгаалах хэрэгсэл	Тоо	Тээврийн хэрэгсэл	Тоо
1	Хүрз	5	ОП цув	10	Ачааны	1
	Сүх	5	Галын костюм /брезентэн хувцас/	15	Суудлын	15
	Галын хор	10	Хорт утааны баг	20	Автобус	1
	Дэгээ	3	хошуувч	25		25
2						
3						

Хүснэгт 10. Томилгоожсон мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний гэрийн хаяг, утасны жагсаалт, бие холбоочин

№	Албан тушаал		Овог нэр	Гэрийн хаяг, утасны дугаар /иридиум утас/	Зарлан мэдээлэл хүргэх холбоочин, түүний утас
	Үндсэн	Томилгоожсон			
Нэг. Аврах бүлэг					
1					
2					
Хоёр. Хэв журам сахиулах бүлэг					

БАЙГУУЛЛАГЫН НӨӨЦ БҮРДҮҮЛЭЛТ :

..... БАЙГУУЛЛАГЫН ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН НӨӨЦ
ХӨРӨНГӨ

.....байгууллага нь жил бүрийн төсөвтөө “Гамшгийн эрсдэлийн зардал”-д зориулж сая төгрөгийг хуваарилдаг бөгөөд төгрөгийг гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд, төгрөгийг аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын үед аврах хор уршгийг арилгах арга хэмжээнд, төгрөгийг сэргээн босгох арга хэмжээнд тус тус зарцуулдаг.

ХҮНСНИЙ НӨӨЦ

ТЕХНИК, БАГАЖ ХЭРЭГСЛИЙН НӨӨЦ

ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН ХУВЦАС, НЭГ БҮРИЙН ХАМГААЛАХ
ХЭРЭГСЛИЙН НӨӨЦ

Штабын даргын ажлын зураг /газрын зураг/

.....сургууль орчмын план зураг байгууллагын ойролцоох зам гарц, нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламж, эрсдэл бүхий газар гэх мэт (*ажилтан, албан хаагчид байраа орхин гарч гарч цугларах томиолгоожуулсан аюулгүй талбай*) зэрэг орсон байна.

Байгууллагын давхар бүрийн авралтын зам, гарцын схем зураг ...гэх мэт

Хүснэгт 11. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй танилцаж, зөвшөөрсөн албан тушаалтан

№	Албан тушаал		Нэр	Огноо	Танилцаж, зөвшөөрсөн албан тушаалтны гарын үсэг
	Үндсэн	Томилгоожсон			
1					
2					

Гамшгийн эрсдэлийн үнэлгээ

Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах үндэслэл нь гамшгийн эрсдэл, эмзэг байдлын үнэлгээ хийх юм.

Гамшгийн эрсдэл, эмзэг байдлын үнэлгээг Гамшгаас хамгаалах хуулийн дагуу мэргэжлийн байгууллагаар хийлгэх боловч тухайн орон нутгийн онцлог, тохиолдож байсан болон болзошгүй аюулт үзэгдэл, ослын судалгаа, сургуулийн давуу болон сул тал, нөлөөлөх гадаад, дотоод хүчин зүйлээр хийсэн орчны шинжилгээ, хүч, хэрэгслийн боломж зэрэгт үндэслэн сургуулийн захиргаа сурагч, холбогдох байгууллага, иргэдийн оролцоонд түшиглэн хийнэ.

“Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө”-г ерөнхий боловсролын сургуулийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд *“Гамшгийн өмнө авч хэрэгжүүлэх арга хэмжээ”, “Гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдлыг хангах төлөвлөгөө”, “Гамшгийн эрсдэлийг бууруулах бэлэн байдлын төлөвлөгөө”* гэх зэргээр олон янзаар нэрлэж байгаа тул нэгдсэн нэг нэршлээр нэрлэнэ.

- Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулахын тулд сургууль, дотуур байрны эрсдэл, эмзэг байдлын болон чадавхын үнэлгээнд тулгуурлах
- Ерөнхий боловсролын сургуулийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулахдаа эрсдэлийн үнэлгээ хийх
- Ерөнхий боловсролын сургуулийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа батлагдсан загварын дагуу боловсруулах

Зөвлөмж

Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулахын тулд сургууль, дотуур байрны эрсдэл, эмзэг байдлын болон чадавхын үнэлгээнд доорх зүйлсийг тусгах нь зүйтэй.

- Сурагч, багш, ажилчдын аюулгүй байдлыг хангах
- Сургалтын үйл ажиллагаа тасалдахгүй байхад анхаарах
- Эрсдэлийг бууруулах урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, төлөвлөх

Ерөнхий боловсролын сургуулийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулж эрсдэлийг үнэлэхдээ доорх зүйлсийг харгалзан үзэж дараах алхмуудыг мөрдөж хийх нь зүйтэй. Үүнд:

Сургуулийн орчны онцлогт тулгуурлан дараах төрлөөр үнэлнэ.

- Байгалийн гамшиг: Газар хөдлөлт, үер цасан шуурга, аянга, ган гачиг.

- Хүний гаралтай эрсдэл: Гал түймэр, цахилгааны доголдол, хий/түлшний алдагдал, халдварт өвчин.
- Нийгмийн эрсдэл: гаднын халдлага, хүчирхийлэл, зам тээврийн осол, олон нийтийн эмх замбараагүй байдал.

Эрсдэлийн үнэлгээний алхам

- Аюул тодорхойлох – Сургуулийн байр, орчны нөхцөлд юу тохиолдож болзошгүй аюул ослыг жагсаах,
- Эмзэг байдлыг үнэлэх – Барилга байгууламжийн бат бөх байдал, барилгажилтын онцлог, бэлэн байдлын түвшин тогтоох,
- Магадлал ба нөлөөллийг үнэлэх – Тухайн эрсдэл хэр олон давтагдах магадлалтай, хэр хэмжээний хор хохирол учруулж болохыг оноогоор илэрхийлэх,
- Урьдчилан сэргийлэх ба хариу арга хэмжээ төлөвлөх, өндөр эрсдэлтэй хүчин зүйлд илүү их нөөц, сургалт чиглүүлэх,

Эрсдэлийн үнэлгээний дүнг ашиглах

- Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах
- Нөөц хэрэгсэлд хөрөнгө хуваарилах
- Сургалт, дадлага хийх чиглэл тогтоох
- Эцэг эх, олон нийтэд мэдээлэх

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулахад анхаарах зүйлс

Сургуулийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах ажлыг аймгийн Онцгой байдлын газар, хэлтэс, сумын Засаг даргын Тамгын газар, Гамшгаас хамгаалах албадтай хамтран зохион байгуулах бөгөөд Онцгой байдлын газар, хэлтэс нь сум, аж ахуйн нэгж, байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах ажилд арга зүйн зөвлөгөө үзүүлнэ.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдсон шаардлагатай арга хэмжээний зардлыг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар жил бүр хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай сургуулийн захирлын тушаалыг гаргуулан хэрэгжилтийн дүнг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан сургуулийн захиргаанд тайлагнана.

- Төлөвлөгөөг боловсруулахдаа батлагдсан загварын дагуу боловсруулна.
- Төлөвлөгөөний хэлбэр, загвар, бүтэц зохион байгуулалтаас гадна амьдралд хэрэгжих чадвар нь чухал бөгөөд гарцаагүй тавигдах шалгууруудыг удирдлага болгох нь зүйтэй.
- Төлөвлөгөө боловсруулахдаа холбогдох багш ажилчидтай хэн ямар үүрэгтэй оролцох, хэн голлох үүргийг хэрэгжүүлэх талаар зөвшилцөн үнэн зөв, бодитой, хэрэгжихүйц байдлаар боловсруулна.
- Төлөвлөгөөг орон нутгийн хөгжлийн ойрын болон хэтийн төлөвлөгөө, гамшгийн давтамж, эрсдэл, эмзэг байдалтай нягт уялдуулан төлөвлөх нь амьдралд хэрэгжих баталгаа болно.
- Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийхдээ (*дадлага, сургуулилт, тухайн жилийн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу орон нутагт зохион байгуулж буй гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургуулилт болон аюулт үзэгдэл, осол тохиолдсон үед*) тодотгоно.

Санал

Ерөнхий боловсролын сургуулийн гамшигийн бэлэн байдлыг хангах, гамшгаас хамгаалах менежментийн бодлого, төлөвлөлтийг сайжруулах санал

- Сургуулийн гамшгаас хамгаалах менежмент буюу эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулах, гамшгаас хамгаалах дадлага, сургуулилалт хийх, үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх мэргэжлийн байгууллагуудын оролцоо, санаачилгыг дэмжих.
- Сургуулийн гамшигийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд танхимын сургалтаар сурагчдад эзэмшүүлж байгаа өөрийгөө хамгаалах, бусдаас тусламж хүсэх, бусдад туслах, мэдлэг, ур чадвар, зан үйлийг хичээлээс гадуурх дадлага сургуулилалт, практик сургалттай хослуулж, амьдралд хэрэгжүүлэх дадал хэвшил болгох үйл ажиллагааг тусган хэрэгжүүлэх.
- Ерөнхий боловсролын сургуульд гамшиг, байгалийн аюулт үзэгдэл зэрэг онцгой нөхцөл байдлын үед ашиглах төсөв, зардлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу төлөвлөж, зарцуулах.
- Цаашид сургуулийн жилийн сургалт, үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөнд “Гамшгаас хамгаалах болон аюулгүй, эрсдэлгүй орчин бүрдүүлэх” гэсэн заалт оруулж хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзлээ.

Ерөнхий боловсролын сургуульд мөрдөж байгаа сургалтын орчин, хэрэглэгдэхүүнийг хөгжүүлэх санал

- Сургуулийн гадаад, дотоод орчны аюулгүй байдлыг бууруулах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх Үүнд:
 - ✓ Анги танхимд байх тавилга эд хогшлыг хананд бэхлэх
 - ✓ Ил байх цахилгааны утсыг далдлах
 - ✓ Аюулгүйн аврах зам, гарцуудын ашиглалтын бэлэн байдлыг хангах, тэмдэг тэмдэглэгээг сайжруулах
 - ✓ Галын унтраах анхан шатны багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангах
 - ✓ Сургуулийн хашааны гаднах гарц, аюулгүйн тэмдэг тэмдэглэгээг сайжруулах
 - ✓ Сургуулийн гадаад орчин үерийн эрсдэл ихтэй тул далан шуудуу байгуулах, аянга зайлуулагч байршуулах
 - ✓ Сургуулийн ойр орчим 50-70 метрээс дотогш шатахуун түгээгүүрийн газар байрлаж байгаа нь эрсдэлтэй тул үүнийг бодлогын түвшинд авч үзэх
- *Сургалтын хэрэглэгдэхүүн, хүний нөөцийг бэлтгэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх Үүнд:*
 - ✓ Байгалын гамшиг, аюулт үзэгдэл тохиолдсон үед хичээл сургалтын үйл ажиллагааг тасралтгүй хүргэх талаарх цахим сургалтыг зохион байгуулах сургалтын хэрэглэгдэхүүний нөөцийг бүрдүүлэхэд эцэг эх, олон нийт,

мэргэжлийн байгууллагын оролцоонд түшиглэх. Жишээ нь: Богино хэмжээний видео бэлтгэж сургалтад ашиглах гэх мэт.

- ✓ Сурагчдад жилд нэг удаа гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх дадлага сургуулилалт хийх бэлэн байдлын сургалтыг зохион байгуулах, шаардлагатай хэрэглэгдэхүүний нөөцийг бэлтгэх.
- ✓ Сургууль бүрийн өсвөрийн аврагч клубийн үйл ажиллагааг өргөжүүлж, үе тэнгийнхнээсээ суралцах боломжид дэмжлэг үзүүлэх.

Дээрх санал болгосон арга хэмжээг сургууль, орон нутаг, үндэсний түвшинд хэрэгжүүлэх байдлыг хүснэгтээр харуулав.

Хэрэгжүүлэх нэгж	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ
Сургуулийн түвшинд	<ul style="list-style-type: none"> • Сургууль бүр эрсдэлийн үнэлгээг хийж, сургуулийн гадаад, дотоод орчны аюулгүй байдлыг бууруулах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх • Сургуулийн гамшгийн эрсдэлийг бууруулах менежментийн төлөвлөгөөг сургалт, үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулах • Өсвөрийн аврагч клубийн үйл ажиллагааг өргөжүүлж, үе тэнгийнхнээсээ суралцах боломжид дэмжлэг үзүүлэх
Орон нутгийн түвшинд	<ul style="list-style-type: none"> • Орон нутгийн Онцгой байдлын байгууллагууд сургуулиудад сургалт, дадлага явуулах чиглэл, зөвлөмж өгч, хамтран ажиллах (Онцгой байдлын газар) • Газарзүйн байршлаас хамааралтай байгалийн гамшиг, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн агуулга, арга зүйг зөвлөмж өгч хамтран ажиллах (Боловсролын газар) • Гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх дадлага сургуулилалт хийх бэлэн байдлын сургалтыг орон нутгийн бүх сургуулийн түвшинд жилд 1 удаа зохион байгуулах, шаардлагатай хэрэглэгдэхүүний болон хүний нөөцийг бэлтгэх